



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 5/79

Чингис хот

Б.Оюунтуяаг үргэлжлүүлэн  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.4, 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэл”, 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”, 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан 2005 оны 15/41/25 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын тасгийн Архивчаар ажиллаж байсан Базаргүрийн Оюунтуяаг тус ажилд нь 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. Б.Оюунтуяагийн сарын үндсэн цалинг ТҮ-6-3 шатлалаар тогтоон, 643238 /зургаан зуун дөчин гурван мянга хоёр зуун гучин найм/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээ, нормын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Архивын тасгийн дарга /Б.Мөнгөнцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030344